НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАТВАР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГА

# “Ай Жэй Эй Эйч-Аудит” ХХК

20.20.он 02.сар 11...өдөр | № 29/2020 | Улаанбаатар хот

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### “Ган хийц” ХК-ийн хувьцаа эзэмшигч танаа

**Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан**

"Ган хийц" ХК-ний 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд "Ган хийц" ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

**Аудитын дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартуудын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайлангийн талаархи компанийн удирдлагын хариуцлага**

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогыг сонгож, хэрэглэх, тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компаний тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүрэг хариуцлагыг хүлээсэн байна.

**Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага**

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компанийн санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг еренхийд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Мөн нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлсон.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 4-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Ган хийц" ХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК

Огноо: 2020. 02. 11

Сангийн сайдын 2012 оны

..... дугаар тушаалын
2 дугаар хавсралт

Регистрийн дугаар: | 2 | 0 | 9 | 0 | 9 | 8 | 8 |

Хаяг : СХД-ийн 7-р хороо Баянхошуу

Шуудангийн хаяг : ____________________

Утас : 70172467 Факс : 70172467

Өмчийн хэлбэр : Төрийн . . . . . хувь хувийн 100 хувь.

A

# "ГАН ХИЙЦ" ХК -ИЙН 2019 ОНЫ ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

| Хянаж хүлээн авсан байгууллагын нэр | Сар, өдор | Гарын үсэг |
|---|---|---|
| СХД СТА | 2/7 2020 | |
| ТҮАЛ Аудит ХХК | 11/06. | Г. Энхмаа. |

**"ГАН ХИЙЦ" ХК -ийн**

**2019 оны санхүүгийн тайлангийн**

**бодит байдлын тухай мэдэгдэл**

2019 оны 12 сарын 31 өдөр

Захирал Д.Оюунзул, ерөнхий нягтлан бодогч Л.Болор-Эрдэнэ бид манай аж ахуйн нэгжийн 2019 оны 12 сарын 31-ны өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 17.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

Захирал ______________ / Д.Оюунзул /

Ерөнхий нягтлан бодогч ______________ / Л.Болор-Эрдэнэ/

ГАН ХИЙЦ ХК
УЛААНБААТАР ХОТ

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

**ГАН ХИЙЦ ХК** — 2019 оны 12 сарын 31 өдөр

( Аж ахуйн нэгжийн нэр )

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2019 оны 1-р сарын 1 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 47 210 818.48 | 25 308 571.64 |
| 1.1.2 | Дансны авлага | 1 371 662 948.64 | 1 382 920 212.4 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | | |
| 1.1.4 | Бусад авлага | | |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | | |
| 1.1.6 | Бараа материал | 296 529 151.29 | 450 394 684.13 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 1 510 939 326.08 | 1 889 780 410.46 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | | |
| 1.1.10 | | | |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **3 226 342 244.5** | **3 748 403 878.64** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 1 399 120 585.77 | 1 325 495 874.08 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | | |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | | |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 323 132 612.61 | 323 132 612.61 |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | | |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | | |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | | |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.9 | | | |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **1 722 253 198.39** | **1 648 628 486.7** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **4 948 595 442.89** | **5 397 032 365.34** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| 2.1.1 | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 350 016 090.81 | 1 365 882 353.88 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 27 478 104.70 | 5 469 412.1 |
| 2.1.1.3 | Татварын өр | 234 507 848.49 | 220 680 013.9 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | 47 604 380.94 | 40 116 540.19 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | 1 295 410 421.14 | 549 481 421.14 |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | | |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | | |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 2 191 265 354.21 | 2 664 177 438.46 |
| 2.1.1.9 | Нөөц /өр төлбөр/ | | |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр | | |
| 2.1.1.12 | | | |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **4 146 282 200.30** | **4 845 807 179.68** |

ГАН ХИЙЦ ХК

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН(үргэлжлэл)

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2019оны 1-р сарын 1 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | | |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | | |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | | |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.5 | | | |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **4 146 282 200.3** | **4 146 282 200.30** |
| **2.3** | **Эздийн өмч** | | |
| 2.3.1 | Өмч: - төрийн | | |
| 2.3.2 | - хувийн | 24 246 400.00 | 24 246 400.00 |
| 2.3.3 | - хувьцаат | | |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | | |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | | |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 798 700 593.97 | 798 700 593.97 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | -20 633 751.37 | -271 721 808.3 |
| 2.3.10 | | | |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **802 313 242.6** | **551 225 185.67** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **4 948 595 442.9** | **5 397 032 365.35** |

Захирал ________ (Д.Оюунзул)

Ерөнхий нягтлан бодогч ________ (Л.Болор-эрдэнэ)

## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

**ГАН ХИЙЦ ХК**
( Аж ахуйн нэгжийн нэр )

2019 оны 12 сарын 31 өдөр

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2019 оны 1-р сарын 1 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **1 145 833 559.45** | **1 151 067 496.15** |
| 2 | Борлуулалтын өртөг | 650 555 947.27 | 855 035 573.35 |
| 3 | **Нийт ашиг( алдагдал)** | **495 277 612.18** | **296 031 922.8** |
| 4 | Түрээсийн орлого | | |
| 5 | Хүүний орлого | 373 388.73 | 49 659.29 |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 8 | Бусад орлого | | |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | | |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 469 804 364.56 | 527 435 033.89 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | 3 285 034.00 | 9 620 814.00 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | 177 454.79 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүсэн олз (гарз) | | |
| 17 | Бусад ашиг ( алдагдал) | | |
| 18 | **Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)** | **22 561 602.35** | **(240 796 811.01)** |
| 19 | Орлогын татварын зардал | 2 256 160.23 | 4 965.92 |
| 20 | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **20 305 442.12** | **(240 801 776.93)** |
| 21 | **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | | |
| 22 | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **20 305 442.12** | **(240 801 776.93)** |
| 23 | **Бусад дэлгэрэнгүй орлого** | | |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| | Гадаад валютынхөрвүүлэлтийн зөрүү | | |
| | Бусад олз (гарз) | | |
| 24 | **Орлогын нийт дүн** | **20 305 442.12** | **(240 801 776.93)** |
| 25 | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)** | | |

Захирал (Д.Оюунзул)

Ерөнхий нягтлан бодогч (Д.Болор-эрдэнэ)

# МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**ГАН ХИЙЦ ХК** 2019 оны 12 сарын 31 өдөр

( Аж ахуйн нэгжийн нэр ) /төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2019 оны 1-р сарын 1 | 2019оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйлажиллагааныменгөнгүйлгээ** | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | **1 656 637 813.99** | **2 616 552 097.03** |
| | борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 1 656 637 813.99 | 2 616 552 097.03 |
| | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | |
| | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | |
| | Буцаан авсан албан татвар | | |
| | с, санхүүжилтийн орлого | | |
| | д мөнгөн орлого | | |
| 1.2 | Мөнгөнзарлагын дүн (-) | **1 582 385 168.55** | **2 176 843 071.14** |
| | Ажиллагчдад төлсөн | 136 761 607.00 | 70 344 604.8 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 44 800 000.00 | 101 500 000.00 |
| | раа материал худалданавахад төлсөн | 466 256 902.16 | 1 886 018 554.99 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 30 205 415.00 | |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлдтөлсөн | 28 360 850.00 | |
| | Хүүний төлбөрт төлсөн | | |
| | Татварын байгууллагад төлсөн | 39 821 730.00 | 65 912 418.00 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | | |
| | Бусад мөнгөн зарлага | 836 178 664.39 | 53 067 493.35 |
| 1.3 | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **74 252 645.44** | **439 709 025.89** |
| 2 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | |
| | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | | |
| | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | |
| | лээн авсан хүүний орлого | | |
| | лээн авсан ногдол ашиг | | |
| | | | |
| 2.2 | Мөнгөнзарлагын дүн (-) | | |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | -57 080 000.00 | -6 611 272.73 |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | |
| | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | | |
| | | | |
| 2.3 | **Хөрөнгө оруулалтынүйл ажиллагааны цэвэр мөнгөнгүйлгээний дүн** | -57 080 000.00 | -6 611 272.73 |
| 3 | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| | Төрөл бүрийн хандив | | |
| | | | |
| 3.2 | Мөнгөнзарлагын дүн (-) | | 455 000 000.00 |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | | 455 000 000.00 |
| | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | | |
| | Төлсөн ногдол ашиг | | |
| | | | |
| 3.3 | **Санхүүгийн үйл ажиллагааныцэвэр мөнгөн гүйлгээнийдүн** | **17 172 645.44** | **-21 902 246.84** |
| 4 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | 17 172 645.44 | -21 902 246.84 |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **30 038 173.04** | **47 210 818.48** |
| 6 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **47 210 818.48** | **25 308 571.64** |

Захирал __________ (Д.Оюунзул)

Ерөнхий нягтлан бодогч __________ ( Л.Болор-эрдэнэ)

ГАН ХИЙЦ ХК

**ГАН ХИЙЦ ХК**
( Аж ахуйн нэгжийн нэр )

# ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2019 оны 12 сарын 31 өдөр
/төгрөгөөр/

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл** | **24 246 400.00** | | | | | **798 700 593.97** | **-20 363 933.49** | **802 583 060.48** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | | | |
| 3 | **Залруулсан үлдэгдэл** | | | | | | | | |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | | | 20 305 442.12 | 20 305 442.12 |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | | | |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | | | |
| 7 | Зарласан ногдол ашиг | | | | | | | **-20 575 260.00** | **-20 575 260.00** |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | | | |
| 9 | **2019 оны 01 -р сарын 01 -ний үлдэгдэл** | **24 246 400.00** | | | | | **798 700 593.97** | **-20 633 751.37** | **802 313 242.60** |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | | | |
| 11 | **Залруулсан үлдэгдэл** | | | | | | | | |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | | | -240 801 776.93 | -240 801 776.93 |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | | | |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | | | |
| 15 | Зарласан ногдол ашиг | | | | | | | **-10 286 280.00** | **-10 286 280.00** |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | | | |
| 17 | **2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл** | **24 246 400.00** | | | | | **798 700 593.97** | **-271 721 808.30** | **551 225 185.67** |

Захирал ____________ (Д.Оюунзул)

Ерөнхий нягтлан бодогч ____________ (Л.Болор-Эрдэнэ)